



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А89

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Худалдан авах ажиллагааны газрын 2016 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 1/202 тоот албан зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Харьяа 9 төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд нийтлэг хэрэгцээтэй эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэхээр шалгарсан эм ханган нийлүүлэх дараах байгууллагуудтай гэрээ байгуулах, гэрээ сунгах, хяналт тавих, санхүүжүүлэх эрхийг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн ерөнхий захирал нарт шилжүүлсүгэй.

- Багц-01: "Тарилгын шингэн нэг"-д "Ай Ви Ко" ХХК,
- Багц-02: "Тарилгын шингэн хоёр"-д "Монгол эм импекс" ХХК,
- Багц-03: "Тариа"-д "Цомбо" ХХК,
- Багц-04: "Антибиотик нэг"-д "Нахиа импекс" ХХК,
- Багц-05: "Антибиотик хоёр"-д "Монос царм трейд" ХХК,
- Багц-06: "Эм"-д "Цомбо" ХХК,
- Багц-07: "Өвчин намдаах эм"-д "Ай Ви Ко" ХХК,
- Багц-08: "Нэг удаагийн хэрэгслүүд-систем"-д "Мөнхийн тун" ХХК,
- Багц-10: "Нэг удаагийн тариур 1"-д "Энто" ХХК,
- Багц-11: "Нэг удаагийн тариур 2"-д "Энто" ХХК,
- Багц-12: "Нэг удаагийн зүү"-д "Энто" ХХК

2. Гэрээ байгууллахаас өмнөх эхний улирлын эм, эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлтийг хасаж тооцон 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаатай байгуулсугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080301